

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1 Оршил.....	4
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.10 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12 Шилэн дансны мэдээлэл	7
2.13 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	7
2.14 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3. Менежментийн захидал.....	9
3.1 Байгууллагын хөрөнгө болон хандив, тусламж, санхүүжилтийн орлогын талаар	9
3.2 Шилэн дансны мэдээллийн талаар.....	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	21
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	22
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	24
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	25

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЦЭНГЭГ УСНЫ НӨӨЦ,
БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨВИЙН
ЗАХИРАЛ Г.НОМИН ТАНАА

2020.02.21 № 06/569
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл, тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1 Оршил

Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төв УТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төв УТҮГ-ын захирал Г.Номин Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн байгууллагын хөрөнгө болон хандив, тусламж, санхүүжилтийн орлого мөн шилэн дансны мэдээллийн талаарх зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төв УТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв УТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдрөөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Интер аудит” ХХК-ийн захирал П.Дарамрагчаа, аудитор Д.Базаргарам нар хариуцаж хэрэгжүүлэв.

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв УТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Интер аудит” ХХК-д 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн №01/19 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв УТҮГ-ын эрхэм зорилго нь Монгол улсын төр, засгаас байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөц, баялгийг зөв зохистой ашиглах талаар гаргасан бодлого, шийдвэрийг олон нийтэд хүргэх, сургалт сурталчилгаа, судалгаа шинжилгээ явуулах, энэ талаарх олон улсын хурал, зөвлөгөөн, сургалт семинар явуулах зэрэг арга хэмжээг зохион байгуулахад оршино.

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв УТҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Байгаль орчин, цэнгэг усны чиглэлээр сургалт сурталчилгаа, судалгаа шинжилгээний ажил явуулах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв УТҮГ нь санхүү нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “асолус” программ хангамж ашигладаг байна.

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв УТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөлтийн үе шатанд 7 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардлын дүнг сонгож, эрсдэлийн түвшинг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүнг 461,210.7 мянган төгрөгөөс тооцон 4,612.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны орлогын дүнгийн 1 хувь болох 7,899.7 мянган төгрөгөөр тооцсон нь хандив, тусламжаар хүлээн авч буй орлогууд тусгайлсан ажил гүйлгээ, данс тодруулгуудад хамааралтай, эсвэл эрсдэл нь бүхэлдээ санхүүгийн тайланд хамааралтай эсэхийг нарийвчлан шалгахтай холбоотой болно.

2.8 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төв УТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 213,499.1 мянган төгрөгөөр буюу 0.94 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	82.5	0.0	-82.5
Бараа материал	58,678.4	70,439.2	11,760.8
Үндсэн хөрөнгө	3,359,032.8	3,133,855.5	-225,177.3
Нийт хөрөнгө	3,417,793.8	3,204,294.7	-213,499.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,417,793.8	3,204,294.7	-213,499.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,417,793.8	3,204,294.7	-213,499.1

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь Ногоон паспорт аяны хүрээнд шинээр авсан хангамжийн материалын үлдэгдлээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь тус байгууллагын нэр дээр бүртгэлтэй дэд станцыг 2014 онд Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК руу шилжүүлэх шийдвэр гарсан боловч данснаас хасаагүй байсныг аудитаар залруулж данснаас хассантай холбоотой байна.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт зориулан 335,617.1 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт төсөв: Хандив тусламжаар Дэлхийн банкнаас 131,121.4 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 306,009.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 13,762.5 мянга, нийт 450,892.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс Бичиг хэргийн зардалд 1,865.4 мянга, урсгал засварын зардалд 5,074.5 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжид 157,803.6 мянга, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 274,389.0 мянга, нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардалд 1,000.0 мянга, нийт 440,132.5 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 10,760.4 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 7 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 2 эрсдэл тодорхойлж нийт 9 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 171,860.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 169,011.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 2,849.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

2.11 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Буцалтгүй тусламжийн хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 2019 оны 9 дүгээр сард Mitsubishi Pickup I200 маркийн автомашиныг хүлээлгэн өгсөн бөгөөд тухайн автомашиныг бүртгэлд тусгасан байдал, үнэлгээ, хөрөнгийн элэгдэл, ашиглалт зэргийг авч үзэх.

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв УТҮГ-ын нэмэлт санхүүжилтийн орлого болон хандив, тусламжийн орлого мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухайн хуулийн хэрэгжилтийг авч үзэх.

2.12 Шилэн дансны мэдээлэл

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв УТҮГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 126 мэдээллийг хугацаанд нь, 22 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2019 оны жилийн эцсийн байдлаар 85.0 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.14 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв УТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв УТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв УТҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Байгууллагын хөрөнгө болон хандив, тусламж, санхүүжилтийн орлогын талаар

Илрүүлэлт:

Буцалтгүй тусламжийн хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 2019 оны 9 дүгээр сард гаалиар орж ирсэн Mitsubishi Pickup I200 маркийн автомашиныг олгосон байна. Тухайн автомашины гэрчилгээ нь Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв УТҮГ-ын нэр дээр гарсан боловч Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас үндсэн хөрөнгөд бүртгэх тогтоол гараагүй байна. Уг автомашиныг хүлээн авсан өдрөөс байгууллага үйл ажиллагаандаа ашиглаж нийт 2,849.1 мянган төгрөгийг шатахуун болон холбогдох зардлыг гаргасан байна.

Эрсдэл:

Тухайн автомашинтай холбоотой засвар үйлчилгээ, шатахуун, элэгдлийн зардлууд гарснаар батлагдсан төсвийн хэтрэлт үүсэх.

Өгсөн зөвлөмж:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл авч дансанд тусган, элэгдлийн зардлыг байгуулж, холбогдох зардлуудыг гаргах. Тусламжийн орлогын дүнг тодорхойлж, үр дүнгийн тайланд тусгах.

Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудиторын өгсөн зөвлөмжийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж ажиллана.

3.2 Шилэн дансны мэдээллийн талаар

Илрүүлэлт:

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан шилэн дансны зарчим болон 6 дугаар зүйлд заасан шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд нь байршуулдаггүй байна.

Эрсдэл:

Шилэн дансны тухайн хууль хэрэгжихгүй байх мөн байгууллагатай холбоотой үйл ажиллагааны мэдээлэл үнэн зөв, иж бүрэн тайлагнагдахгүй байх.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 4.1.1 мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх зармыг мөрдөж ажиллах. Мөн тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллүүдийг цаг хугацаанд нь иж бүрэн тайлагнаж байх.

Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудиторын өгсөн зөвлөмжийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>58,760,962.97</u>	<u>70,439,164.20</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.0	0.0
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0.0	0.0
33	АВЛАГА	82,556.10	0.0
335	Бусад авлага	82,556.10	0.0
3351	Байгууллагаас авах авлага	82,556.10	0.0
34	УРЬДЧИЛГАА	0.0	0.0
35	БАРАА МАТЕРИАЛ	58,678,406.87	70,439,164.20
351	Түүхий эд материал	47,406,018.20	52,274,022.20
35110	Тусгай зориулалттай материал	47,406,018.20	52,274,022.20
354	Хангамжийн материал	11,272,388.67	18,165,142.00
35410	Бичиг хэргийн материал	399,087.00	855,317.00
35420	Аж ахуйн материал	120,573.67	141,857.00
35450	Барилгын засварын материал	2,086,100.00	1,931,100.00
35470	Бусад хангамжийн материал	8,666,628.00	15,236,868.00
36	НӨӨЦИЙН БАРАА	0.0	0.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,359,032,836.02</u>	<u>3,133,855,522.21</u>
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0.0	0.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,359,032,836.02	3,133,855,522.21
392	Биет хөрөнгө	3,358,927,836.02	3,278,996,388.52
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,213,032,846.00	3,044,021,005.00
30202	Хуримтлагдсан элэгдэл	-19,600,678.69	-54,141,062.16
30203	Авто тээврийн хэрэгсэл	0.0	30,887,609.50
39204	Хуримтлагдсан элэгдэл	0.0	-29,999,868.24
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,738,675,190.00	1,738,675,190.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-1,736,492,414.49	-1,737,397,589.77
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	243,754,840.00	243,754,840.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-148,165,336.80	-169,712,992.12
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	58,845,400.00	58,845,400.00
39217	Ном	8,877,990.00	8,877,990.00
393	Биет бус хөрөнгө	105,000.00	45,000.00
39301	Програм хангамж	1,675,000.00	1,675,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,570,000.00	-1,630,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,417,793,798.99</u>	<u>3,204,294,686.41</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>0.0</u>	<u>0.0</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.0	0.0
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.0	0.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,417,793,798.99</u>	<u>3,204,294,686.41</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,417,793,798.99	3,204,294,686.41

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв УТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

512	Хуримтлагдсан үр дүн	3,397,394,842.70	3,186,307,730.12
51210	Өмнөх үеийн үр дүн	7,114,617,592.86	3,399,806,842.70
51220	Тайлант үеийн үр дүн	-3,717,222,750.16	-213,499,112.58
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	17,986,956.29	17,986,956.29
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	2,412,000.00	0.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>3,417,793,798.99</u>	<u>3,204,294,686.41</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	928,007,267.00	789,971,740.71
11	ТАТВАРЫН ОРЛОГО	0.0	0.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	51,241,667.00	3,461,708.71
120	Нийтлэг татварын бус орлого	42,780,056.00	3,461,708.71
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	42,780,056.00	3,461,708.71
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.0	0.0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	42,780,056.00	3,461,708.71
120009	Бусад орлого	8,461,611.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	876,765,600.00	786,510,032.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	299,744,600.00	335,617,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	299,744,600.00	335,617,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	577,021,000.00	450,892,932.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	228,321,600.00	131,121,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	334,169,400.00	306,009,032.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,530,000.00	13,762,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,182,828,567.46	858,284,986.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,182,828,567.46	858,284,986.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,149,684,155.63	844,942,056.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	202,639,486.51	237,725,721.26
210101	Үндсэн цалин	164,936,374.99	196,996,521.26
210102	Нэмэгдэл	16,817,111.52	20,577,500.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,886,000.00	20,151,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,104,399.47	29,886,456.10
210201	Тэтгэврийн даатгал	16,978,603.73	20,266,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,122,325.47	2,384,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,482,194.25	1,989,956.10
210204	Ажилгүйдлийн даатгал	411,025.09	476,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,110,250.93	4,768,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,893,433.00	34,052,165.50
210301	Гэрэл, цахилгаан	19,578,845.00	18,818,588.00
210302	Түлш, халаалт	11,121,333.00	10,486,557.50
210303	Цэвэр, бохир ус	4,193,255.00	4,747,020.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,369,671.42	15,206,042.30
210401	Бичиг хэрэг	8,052,323.00	4,154,580.00
210402	Тээвэр, шатахуун	5,703,000.00	2,908,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,407,567.09	6,469,929.63
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,206,781.33	1,673,432.67
210408	Бараа материал акталсны зардал	0.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,327,298.00	6,029,699.00
210601	Багаж хэрэгсэл	0.00	114,399.00

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв УТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210604	Урсгал засвар	1,327,298.00	5,915,300.00
2107	Томилолт, зочны зардал	2,164,500.00	36,000.00
210702	Дотоод албан томилолт	2,164,500.00	36,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	287,101,800.00	165,152,068.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	285,601,800.00	163,134,060.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	0.0	483,408.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.0	34,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	578,083,567.23	356,853,904.21
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.0	0.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	276,830,119.00	273,400,748.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	301,253,448.23	83,453,156.21
210904	Найдваргүй авлагын алдагдал	0.0	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,144,411.83	13,342,930.61
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.0	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.0	1,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	33,144,411.83	12,342,930.61
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,614,411.83	1,582,498.61
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	14,530,000.00	10,760,432.00
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-254,821,300.46	-68,313,246.27
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,462,401,449.70	145,185,866.31
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.0	145,185,866.31
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	3,462,401,449.70	0.0
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-3,462,401,449.70	-145,185,866.31
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-3,717,222,750.16	-213,499,112.58

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>885,227,211.00</u>	<u>786,510,032.00</u>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	0.0	0.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,461,611.00	0.0
120	Нийтлэг татварын бус орлого	0.0	0.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.0	0.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.0	0.0
124	Бусад орлого	8,461,611.00	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	876,765,600.00	786,510,032.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	299,744,600.00	335,617,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	299,744,600.00	335,617,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	577,021,000.00	450,892,932.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	228,321,600.00	131,121,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	334,169,400.00	306,009,032.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,530,000.00	13,762,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>885,227,211.00</u>	<u>786,510,032.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	885,227,211.00	786,510,032.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	852,082,799.17	773,167,101.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	200,885,115.03	237,725,721.26
210101	Үндсэн цалин	173,103,715.03	196,996,521.26
210102	Нэмэгдэл	10,629,700.00	20,577,500.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,151,700.00	20,151,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,877,400.00	29,803,900.00
210201	Тэтгэврийн даатгал	16,584,900.00	20,266,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,073,200.00	2,384,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,658,500.00	1,907,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	414,600.00	476,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,146,200.00	4,768,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,893,433.00	34,052,165.50
210301	Гэрэл, цахилгаан	19,578,845.00	18,818,588.00
210302	Түлш, халаалт	11,121,333.00	10,486,557.50
210303	Цэвэр, бохир ус	4,193,255.00	4,747,020.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,314,397.09	14,960,665.63
210401	Бичиг хэрэг	9,300,230.00	4,293,570.00
210402	Тээвэр, шатахуун	5,516,000.00	2,908,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,407,567.09	6,469,929.63
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,090,600.00	1,289,066.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	686,698.00	6,194,689.00
210601	Багаж техник хэрэгсэл	0.0	434,389.00

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв УТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210604	Урсгал засвар	686,698.00	5,760,300.00
2107	Томилолт, зочны зардал	2,164,500.00	36,000.00
210702	Дотоод албан томилолт	2,164,500.00	36,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	296,080,587.05	165,152,068.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	294,580,587.05	163,134,060.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,500,000.00
210803	Даатгалын үйлчлэгэ	0.0	483,408.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.0	34,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	273,180,669.00	285,241,892.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.0	0.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	273,180,669.00	285,241,892.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,144,411.83	13,342,930.61
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.0	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.0	1,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	33,144,411.83	12,342,930.61
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,614,411.83	1,582,498.61
213304	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	14,530,000.00	10,760,432.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>0.0</u>	<u>0.0</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.0	0.0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.0	0.0	7,117,029,592.86	7,117,029,592.86
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0	0.0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.0	0.0	7,117,029,592.86	7,117,029,592.86
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.0	0.0	0.0	0.0
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.0	0.0	0.0	0.0
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0	0.0
Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	-3,717,222,750.16	-3,717,222,750.16
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.0	17,986,956.29	3,399,806,842.70	3,417,793,798.99
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0	0.0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.0	17,986,956.29	3,399,806,842.70	3,417,793,798.99
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.0	0.0	0.0	0.0
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.0	0.0	0.0	0.0
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0	0.0
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.0	0.0	0.0	0.0
Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	-213,499,112.58	-213,499,112.58
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.0	17,986,956.29	3,186,307,730.12	3,204,294,686.41

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0	0.0	0.0
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	335,617,100.00	334,034,601.39	1,582,498.61	99.5
УРСГАЛ ЗАРДАЛ	335,617,100.00	334,034,601.39	1,582,498.61	99.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	335,617,100.00	334,034,601.39	1,582,498.61	99.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	238,432,700.00	237,725,721.26	706,978.74	99.7
Үндсэн цалин	197,703,500.00	196,996,521.26	706,978.74	99.7
Нэмэгдэл	20,577,500.00	20,577,500.00	0.0	100
Унаа хоолны хөнгөлөлт	20,151,700.00	20,151,700.00	0.0	100
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,803,900.00	29,803,900.00	0.0	100
Тэтгэврийн даатгал	20,266,700.00	20,266,700.00	0.0	100
Тэтгэмжийн даатгал	2,384,300.00	2,384,300.00	0.0	100
ҮОМШӨ-ний даатгал	1,907,400.00	1,907,400.00	0.0	100
Ажилгүйдлийн даатгал	476,800.00	476,800.00	0.0	100
Эрүүл мэндийн даатгал	4,768,700.00	4,768,700.00	0.0	100
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,451,400.00	34,052,165.50	399,234.50	98.8
Гэрэл, цахилгаан	18,921,800.00	18,818,588.00	103,212.00	99.5
Түлш, халаалт	10,754,800.00	10,486,557.50	268,242.50	97.5
Цэвэр, бохир ус	4,774,800.00	4,747,020.00	27,780.00	99.4
Хангамж, бараа материалын зардал	13,327,000.00	13,095,265.63	231,734.37	98.3
Бичиг хэрэг	2,428,300.00	2,428,170.00	130.00	99.9
Тээвэр, шатахуун	2,909,000.00	2,908,100.00	900.00	99.9
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,699,100.00	6,469,929.63	229,170.37	96.6
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,290,600.00	1,289,066.00	1,534.00	99.9
Эд хогшил, урсгал засварын зардал	1,136,700.00	1,120,189.00	16,511.00	98.5
Багаж, техник хэрэгсэл	450,000.00	434,389.00	15,611.00	96.5
Урсгал засвар	686,700.00	685,800.00	900.00	99.9
Томилолт, зочны зардал	109,800.00	36,000.00	73,800.00	32.8
Дотоод албан томилолт	109,800.00	36,000.00	73,800.00	32.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,458,200.00	7,348,508.00	109,692.00	98.5
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,346,000.00	5,330,500.00	15,500.00	99.7
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,500,000.00	0.0	100
Даатгалын үйлчилгээ	483,500.00	483,408.00	92.00	99.9
Тээврийн хэрэгслийн татвар	69,300.00	34,600.00	34,700.00	49.9
Тээврийн хэрэгслийн оношлогоо	59,400.00	0.0	59,400.00	0.0

Бараа үйлчилгээний бусад зардал	10,897,400.00	10,852,852.00	44,548.00	99.6
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,897,400.00	10,852,852.00	44,548.00	99.6
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	335,617,100.00	334,034,601.39	1,582,498.61	100
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	335,617,100.00	334,034,601.39	1,582,498.61	100
Улсын төсвөөс санхүүжих	335,617,100.00	334,034,601.39	1,582,498.61	100
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0	0.0	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0	0.0	0.0
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
Ажиллагсдын тоо	25	25	0	100
Удирдах ажилтан	1	1	0	100
Гүйцэтгэх ажилтан	20	20	0	100
Үйлчлэх ажилтан	4	4	0	100
Гэрээт ажилтан	0	0	0	0

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.0
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		440,132,500.00
УРСГАЛ ЗАРДАЛ		440,132,500.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		439,132,500.00
Хангамж, бараа материалын зардал		1,865,400.00
Бичиг хэрэг		1,865,400.00
Эд хогшил, урсгал засварын зардал		5,074,500.00
Урсгал засвар		5,074,500.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		157,803,560.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		157,803,560.00
Бараа үйлчилгээний бусад зардал		274,389,040.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		274,389,040.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,000,000.00
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал		1,000,000.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		450,892,932.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		131,121,400.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		306,009,032.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		13,762,500.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.0

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2020.02.17	Аудитын нэр:	2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан	Аудитын код:
Шалгагдсан байгууллагын нэр:	Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв			САГ-2020/110/СТА-ТШЗ
				Мянган төгрөгөөр

Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
		Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5
Буцалтгүй тусламжийн хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 2019 оны 9 дүгээр сард гаалиар орж ирсэн Mitsubishi Pickup 1200 маркийн автомашиныг олгосон байна. Тухайн автомашины гэрчилгээ нь Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв УТҮГ-ын нэр дээр гарсан боловч Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас үндсэн хөрөнгөд бүртгэх тогтоол гараагүй байна. Уг автомашиныг хүлээн авсан өдрөөс байгууллага үйл ажиллагаандаа ашиглаж нийт 2,849.1 мянган төгрөгийг шатахуун болон холбогдох зардлыг гаргасан байна.	2,849.1	Зөвлөмж	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Г.Номин О.Баярцэцэг
Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан шилэн дансны зарчим болон 6 дугаар зүйлд заасан шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд нь байршуулдаггүй байна.	-	Зөвлөмж	Ерөнхий нягтлан бодогч	О.Баярцэцэг
Нийт дүн	2,849.1			

